| 66 | Тавантолгойн нүүрсний ордыг хэрхэн үр ашигтай ашиглах вэ                           | Ерөнхийлөгчийн ахлах зөвлөх П.Цагаан | 2011-08-18 |   | 85 | 09:30-13:00 | 100 x | 2 x | 51 x  | 49 x | 316 -MB | 4 |
| 67 | Улс төрийн намын шинэчлэлийн хүрээнд танилцуулга уулзалт                           | ХЭИОБ-ын зөвлөх Ч.Сосормаа           | 2011-09-05 |   | 35 | 09:30-13:00 | 101 x | 6 x | 101 x |      | 2 -MB   | 3 |
| 68 | Намуудын талаар болоод сонгуулийн талаар олон улсын судалгааны танилцуулга уулзалт | ХЭИОБ-ын зөвлөх Ч.Сосормаа           | 2011-09-08 |   | 31 | 09:30-12:45 | 33 x  | 1 x | 11 x  | 22 x | 223 -MB | 2 |
| 69 | "Технологи" үндэсний хөтөлбөрийн төслийн танилцуулга, хэлэлцүүлэг                  | Ерөнхийлөгчийн зөвлөх Р.Болд         | 2011-09-09 | , Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо  | 82 | 09:30-13:00 | -     | -   | -     |      | 145 -MB |   |



|    |   |   |            |                           |    |             |       |     |       |      |         |   |
|----|---|---|------------|---------------------------|----|-------------|-------|-----|-------|------|---------|---|
| 70 | Намуудын талаар болоод сонгуулийн талаар олон улсын судалгааны танилцуулга уулзалт                                | ХЭИОБ-ын зөвлөх Ч.Сосормаа                                  | 2011-09-12 |                           | 28 | 09:30-13:00 | 67 x  | 2 x | 34 x  | 33 x | 315 -MB | 3 |
| 71 | Иргэний оролцооны эрх зүйн хүрээний зохицуулалтыг боловсронгуй болгох ажлын хэсгийн хуралдаан                     | ХЭИОБ-ын зөвлөх Ч.Сосормаа                                  | 2011-09-14 |                           | 34 | 14:30-17:00 |       |     |       |      | 120 -MB | - |
| 72 | Агаарын бохирдлын уулзалт   | Тамгын газрын дарга Д.Баттулга                              | 2011-09-29 |                           | 12 | 09:00-12:30 | 165 x | 4 x | 165 x |      | 203 -MB | 4 |
| 73 | Төмөр замын зүтгүүрийн талаар төмөр замын дэд зөвлөлийн хуралдаан   | Ерөнхийлөгчийн зөвлөх Л.Дашдорж                             | 2011-09-30 |                           | 29 | 09:00-12:30 | 67 x  | 4 x | 63 x  |      | 118 -MB | 1 |
| 74 | “Монгол орны говийн экологийн бүс нутагт уул уурхайн хөгжлийг нөлөө багатай төлөвлөх” төслийн танилцуулах уулзалт | The Nature Conservancy                                      | 2011-10-06 |                           | 60 | 14:30-17:00 | 36 x  | 2 x | 36 x  |      | 80 -MB  | - |
| 75 | Мэдээллийн технологид суурилсан эрүүл мэндийн үйлчилгээ сэдэвт хэлэлцүүлэг  | Ерөнхийлөгчийн зөвлөх Л.Дашдорж                             | 2011-10-07 | Эрүүл мэндийн сайд Цолмон | 58 | 14:30-17:00 | 190 x | 7 x | 184 x | -    | 959 -MB | 3 |
| 76 | “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоотой хамтран УИХ-ын гишүүдтэй уулзах уулзалт”                     | УИХ-ын гишүүн С.Оюун  | 2011-10-10 |                           | 61 | 14:30-17:00 | -     | -   | -     |      |         | - |
| 77 | “Орон нутгийн хурлын сонгуулийн тухай хуулийн зарим асуудлууд”  | Нийслэлийн Ардчилсан нам, Ардчилал сонин                    | 2011-10-11 |                           | 78 | 14:30-17:00 | 23 x  | 1 x | 23 x  |      | 108 -MB | 2 |
| 78 | Хуулчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг   | УИХ-гишүүн Ж.Тэмүүжин                                       | 2011-10-13 | Өмгөөлөгч, шүүгчид        | 55 | 09:30-17:30 | 17 x  | 1 x | 17 x  |      | 94 -MB  | 2 |
| 79 | Хүний нэр төр алдар хүндийн эрх зүйн хамгаалалт хэлэлцүүлэг   | Ерөнхийлөгчийн хуулийн асуудал хариуцсан туслах Ж.Баярцэцэг | 2011-10-14 |                           | 46 | 14:30-17:30 | 115 x | 3 x | 115 x |      | 101 -MB | 2 |
| 80 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх макро эдийн засгийн уялдаа холбоог сайжруулах дэд зөвлөлийн хурал            | Ерөнхийлөгчийн зөвлөх Л.Дашдорж                             | 2011-10-11 | Одхүү гишүүн              | 80 | 09:30-18:30 | -     | 1 x | 23 x  |      | 156 -MB | 1 |
| 81 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх төлбөрийн тэнцэл, валютын бодлогын дэд зөвлөлийн хурал                       | Ерөнхийлөгчийн зөвлөх Л.Дашдорж                             | 2011-10-12 | Монгол банкны Ерөнхийлөгч | 60 | 14:30-17:30 | -     | 3 x | 74 x  |      | 320 -MB | 3 |
| 82 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх мөнгөний бодлогын дэд зөвлөлийн хурал  | Ерөнхийлөгчийн зөвлөх                                       | 2011-10-13 | Монгол банк               | 72 | 16:30-17:30 | -     | 3 x | 90 x  |      | 181 -MB | 3 |



|    |  |  |            |                             |    |             |      |     |      |      |         |   |  |
|----|--|--|------------|-----------------------------|----|-------------|------|-----|------|------|---------|---|--|
|    |  | Л.Дашдорж  |            |                             |    |             |      |     |      |      |         |   |  |
| 83 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх төсвийн бодлогын дэд зөвлөлийн хурал                                      | Ерөнхийлөгчийн зөвлөх<br>Л.Дашдорж   | 2011-10-14 | Сангийн яам                 | 85 | 11:00-12:30 | -    | 2 x | 51 x | -    | 111 -MB | 2 |  |
| 84 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх эдийн засгийн өсөлт, бодит серторын бодлогын дэд зөвлөлийн хурал          | Ерөнхийлөгчийн зөвлөх<br>Л.Дашдорж   | 2011-10-17 | Үндэсний статистекийн хороо | 83 | 09:30-13:30 | 83 x | 3 x | 83 x | 83 x | 166 -MB | 2 |  |
| 85 | Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл ба Газрын тос боловсруулах үйлдвэр                      | Монголын байгаль хамгаалах иргэний хөдөлгөөнүүдийн эвсэл" ТББ  | 2011-10-26 |                             | 60 | 14:30-17:30 | 65x  | 4x  | 65x  | 65x  | 125Mb   | 2 |  |
| 86 | "Хүнсний аюулгүй байдал" сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг   | ҮАББ-ын зөвлөх<br>М.Батчимэг   | 2011-10-28 |                             | 62 | 14:30-18:00 | 90x  | 4x  | 47x  | 26x  | 226Mb   | 3 |  |
| 87 | "Монгол Улсын Эрүүл мэндийн санхүүжилт" сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг  | Ерөнхийлөгчийн зөвлөх<br>Л.Дашдорж   | 2011-11-04 |                             | 74 | 14:30-17:30 | 200x | 7x  | 139x | 43x  | 296Mb   | 3 |  |
| 88 | Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулга хэвлэлийн бага хурал                         | Ерөнхийлөгчийн хэвлэлийн төлөөлөгч<br>С.Батзаяа,<br>Ерөнхийлөгчийн хуулийн асуудал хариуцсан туслах<br>Ж.Баярцэцэг | 2011-11-11 | Хэвлэлийнхэн                | 16 | 14:30-18:00 | -    | -   | -    |      |         |   |  |
| 89 | "Монгол Улсын төмөрлөгийн аж үйлдвэрийн хөгжлийн тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам" нээлттэй хэлэлцүүлэг | Ерөнхийлөгчийн зөвлөх<br>Л.Дашдорж   | 2011-11-16 |                             | 56 | 14:30-18:00 | 83 x | 3x  | 83x  |      | 99Mb    | 1 |  |
| 90 | Хэнтий аймгийн иргэдийн төлөөлөл "Иргэний танхим"-ын үйл ажиллагаатай танилцах                                 | ОНХМБА-ны референт<br>Ш.Отгон-Өлзий  | 2011-11-16 |                             | 20 | 14:30-17:30 | -    | -   | -    |      |         |   |  |
| 91 | Согтууруулах ундааны хяналтын тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг  | ХЭИОБ-ын зөвлөх<br>Ч.Сосормаа  | 2011-11-18 |                             | 32 | 14:00-15:30 | 13x  | 1x  | 13x  |      | 87Mb    |   |  |
| 92 | "Монгол Улсад төвлөрлийг сааруулах орон нутагт эрх мэдэл олгох иргэний оролцоог хангах" нээлттэй хэлэлцүүлэг   | Ерөнхийлөгчийн зөвлөх<br>Л.Дашдорж   | 2011-12-01 |                             | 51 | 10:00-13:00 | 46x  | 2x  | 46x  |      | 504Mb   | 2 |  |



|             |   |  |            |  |             |              |              |             |              |             |                  |            |
|-------------|---|--|------------|--|-------------|--------------|--------------|-------------|--------------|-------------|------------------|------------|
| 93          | Хөгжлийн бодлого, хууль эрх зүйн бодлого                | Нэгдсэн үндэсний байгуулага UNDP           | 2011-12-02 |  | 49          | 09:30-13:25  | -            | -           | -            |             | 87Mb             |            |
| 94          | Байгаль орчны манлайлагч хөтөлбөрийн нээлтийн ажиллагаа | УИХ-ын гишүүн С.Оюун                       | 2011-12-02 |  | 58          | 14:30-15:30  | -            | -           | -            |             |                  |            |
| 95          | Хүний эрх, эрх чөлөөний тухай 2-р салбар хуралдаан      | Салбар хуралдаан                           | 2011-12-09 |  | 56          | 10:30-12:30  | -            | -           | -            |             |                  |            |
| 96          | Нарны эрчим хүч, станцын талаар нээлттэй хэлэлцүүлэг    | Ерөнхийлөгчийн зөвлөх Л.Дашдорж            | 2011-12-23 |  | 50          | 09:30-12:30  | -            | -           | -            |             |                  |            |
| 97          | Стратегийн ордуудын талаар нээлттэй хэлэлцүүлэг         | УИХ-ын гишүүн Алтай, Батэрдэнэ, Сэдваанчиг | 2011-12-26 |  | 20          | 15:30-17:30  | -            | -           | -            |             |                  |            |
| 98          | Монгол –XX зууны анхны үндэстэн-улс мөн                 | Түүхч залуучуудын клуб                     | 2011-12-27 |  | 42          | 17:30-19:00  | -            | -           | -            |             |                  |            |
| <b>Нийт</b> |   |  |            |  | <b>4781</b> | <b>11850</b> | <b>1495x</b> | <b>159x</b> | <b>3224x</b> | <b>230x</b> | <b>60.960 Mb</b> | <b>100</b> |

### 2011 оны 1-р сарын 01 нээс 12-р сарын 20 ны байдлаар

1. Нээлттэй хэлэлцүүлэг болон хурал зөвлөгөөнд **4781** иргэнд үйлчилсэн. /Давхардсан тоогоор/
2. 2011 оны байдлаар **98** удаагийн нээлттэй хэлэлцүүлэг, хуулийн төслийн танилцуулага, салбар зөвлөлийн болон ажлын хэсгийн хуралдаан, иргэдийн уулзалт хийгдсэн.
3. 98 удаагийн нээлттэй хэлэлцүүлэг, хуулийн төслийн танилцуулага, салбарын болон ажлын хэсгийн хуралдаан нь дунджаар **11850** цагийн хэлэлцүүлэг зохион байгуулагсан.
4. Хот хөдөөгийн **372** иргэд Иргэний танхимын үйл ажиллагаатай танилцсан.
5. Нэг жилийн хугацаанд Иргэний танхимд **98** удаагийн хэлэлцүүлэгт **159** илтгэл, **3224** хуудас илтгэл тавигдсан байна.
6. Хуралын тэмдэглэл **230** хуудас хөтөлсөн.
7. Нийт хэлэлцүүлгийн болон хуулийн төслийн материалыг Иргэний танхим-ын архивт цаасаар хавсарган **1495** хуудас архивлан хадгалсан.
8. Нийт хэлэлцүүлгийн аудио бичлэг, илтгэл, зураг болон зарим дүрст файлыг архивлан **60 Gb** хэмжээтэйгээр архивлан хадгалсан.



2011.07.01-ны байдлаар Булган, Говь-Алтай, Дархан-уул, Дорноговь, Завхан, Орхон, Өмнөговь, Хөвсгөл, Сүхбаатар зэрэг 9 аймаг, нийслэл УБ болон Хан-уул, Баянгол, Налайх зэрэг 3 дүүрэгт байгуулагдаад үйл ажиллагаагаа хэрэгжүүлж эхлэсэн байна.

## **ХОЁР**

### **2.1 Үүрэг даалгавар, тушаал шийдвэрийн хүрээнд**

➤ Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2011 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн № 73 тоот захирамжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд “төрийн болон орон нутгийн шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа хийж үнэлгээ өгөх, санал дүгнэлт боловсруулах, ажлын тайлан бэлтгэх” төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажиллаа. Бэлтгэл ажлын хүрээнд хамтран ажиллах байгууллагад төслийг хэрэгжүүлэх саналыг хүргэж улмаар төслийн санхүүжилтийг бүрдүүлэхээр ажиллаж байна.

Дээрхи төслийг “Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн”-тэй хамтран хэрэгжүүлэхээр 2011 оны 06 дүгээр сарын 10-наас 2011 оны 09 дугаар сарын 10 хүртэл 3 сарын хугацаатай гэрээг байгууллаа.

Дээрхи төслийг хэрэгжүүлэх явцад хууль эрх зүйн орчны зохицуулалтанд судалгаа хийх хугацаа шаардагдаж байгаа тул гэрээг дахин 3 сараар сунгах болсон

### **Шийдвэр гаргах түвшин дэхь иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд хууль, эрх зүйн орчинд судалгаа хийж үнэлгээ өгөх, багц хуулийн төсөл боловсруулах ажлын даалгаврын төсөл**

2011.06.08

#### **Нэг. Төслийг хэрэгжүүлэх баг:**

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг
- Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд хөдөлгөөн

#### **Хоёр. Төслийн шаардлага:**

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2009-2013 оны бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1 дэх хэсэгт заасан “Ерөнхийлөгчийн санаачлах хууль, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын төсөлд олон нийтээс санал авах зорилготой “Иргэний танхим” байгуулан ажиллуулж, түүний жишгээр бүх аймаг, хот, сум, орон нутагт иргэдийн оролцоотойгоор шийдвэр гаргахад зориулсан танхим ажиллуулах хуулийн орчинг бүрдүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлэх,
- ❖ Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар байгуулагдсан “Иргэний танхим”-ын үйл ажиллагааг тогтмолжуулах, төрийн болон орон нутгийн болон шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд хууль эрх зүйн зохицуулалтад үнэлгээ хийх замаар судалгаа хийж цаашдын хуулийн орчныг бүрдүүлэх үйл ажиллагааг тодорхойлох шаардлага байна.
2. 2010 онд УИХ-р батлагдсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3.4.2 дах хэсэгт “Төрийн бодлого боловсруулах, төрд хяналт тавихад төрийн бус байгууллагын тэгш оролцоо, зөвшилцлийг хангах замаар иргэний нийгмийн төлөвшлийг дэмжинэ. Нийгэмд үйлчилдэг төрийн бус





байгууллагуудын үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчныг бүрдүүлж, төр-иргэний нийгмийн хамтын ажиллагааны бүтээлч арга, хэлбэрүүдийг хөгжүүлнэ”, 4.2.3 дахь хэсэгт “Монгол улсын иргэд, иргэний нийгмийн байгууллагууд үндэсний аюулгүй байдлыг хангах тухай хууль тогтоомж, энэхүү үзэл баримтлалыг чанд мөрдлөг болгож, тэдгээрийг хэрэгжүүлэхэд идэвхитэй оролцоно” гэж тусгагдсан.

- ❖ Энэхүү заалт нь бусад холбогдох хууль эрх зүйн зохицуулалтаар хэрэгжиж байгаа эсэхэд үнэлгээ өгөх санал зөвлөмж боловсруулах шаардлагатай байна.

#### **Гурав. Төслийн зорилго:**

- Төрийн болон орон нутгийн шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа хийж үнэлгээ өгөх, санал дүгнэлт боловсруулах, судалгааны ажлын тайлан бэлтгэх,

#### **Дөрөв. Төслийн зорилт, үйл ажиллагаа:**

1. Төрийн болон орон нутгийн түвшинд иргэдийн оролцооны эрх зүйн зохицуулалтын байдал ямар байгаа талаар судалгааны тайлан болон бодлогын баримт бичгүүд зэрэгт үнэлгээ хийх, ажлын тайлан бэлтгэх,
2. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, эрх зүйн баримт бичгүүдэд иргэдийн оролцооны талаас нь эрх зүйн орчны шинжилгээ хийх, экспертүүдийн хүрээнд хэлэлцүүлж, санал зөвлөмжийг авах /ингэхдээ иргэдийн оролцооны эрх зүйн байдлыг үнэлэх үнэлгээний шалгуурыг багийн гишүүдийн оролцоотой бэлтгэж, энэ шалгууртаа үндэслэх/
3. Эрх зүйн орчны шинжилгээний үр дүнд үндэслэн тухайн хууль тогтоомжуудад оруулах нэмэлт өөрчлөлтийн санал бэлтгэх, экспертүүдийн хүрээнд хэлэлцүүлж санал зөвлөмжийг авах

Үнэлгээний хүрээнд дараахь хууль тогтоомжуудыг судална.

- УИХ-ын дэгийн тухай хууль
- Засгийн газрын тухай хууль
- Хуулийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль
- Нууцын тухай хуулиуд
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журмын тухай хууль
- Төсвийн тухай хуулиуд
- Газрын тухай хууль
- Төрийн бус байгууллагын тухай хууль болон төсөл
- Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл
- Аймаг нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дэг, зарим сумдын ИТХ-ын дэг
- Баг, хорооны нийтийн хурлын зохицуулалт
- Энэ чиглэлд хийгдсэн судалгаа, зөвлөмж
- “Орон нутгийн эрх мэдлийг иргэдийн оролцоотой нэмэгдүүлэх нь “ чуулганы баримт бичиг, оролцогчдын хэлсэн үг, санал
- Бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичгүүд

#### **Тав. Төслөөс гарах үр дүн:**





1. Төрийн болон орон нутгийн түвшинд шийдвэр гаргахад иргэдийн оролцооны эрх зүйн зохицуулалтын талаар хийгдсэн судалгааны тайлангуудыг нэгтгэсэн танилцуулга,
2. Иргэдийн оролцооны эрх зүйн зохицуулалтын байдалд дүн шинжилгээ хийсэн ажлын тайлан,
3. Иргэдийн оролцоог тогтмолжуулах, дээшлүүлэх, илүү өгөөжтэй үр ашигтай оролцоо байх чиглэлд холбогдох хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлт оруулах санал дүгнэлт зэрэг хамтдаа бэлэн болсон байна.

### Зургаа. Багийн гишүүдийн танилцуулга

- Р.Бурмаа – Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд хөдөлгөөний тэргүүн Монгол Улсын Ерөнхийлөгчийн орон тооны бус зөвлөх
- Б.Хишигсайхан – Хүний эрхийн хуульч, НҮБХХ-ийн Хууль зүйн үйлчилгээний хүртээмж ба хүний эрх төслийн зөвлөх
- Ш.Бямбаа – Бие даасан судлаач, Монголын баг сумын холбооны гүйцэтгэх захирал
- Н.Ариунболд – Бие даасан судлаач, “Зөв хууль” хууль зүйн товчооны захирал
- С.Оюунтуяа – Сонгогчдын боловсрол төвийн гүйцэтгэх захирал

#### Экспертийн багийн гишүүд:

- Ч.Өнөрбаяр /ҮАБЗ-ийн Ажлын албаны даргын үүрэг гүйцэтгэгч/
- Г.Эрдэнэбат /Улсын ерөнхий прокурорын туслах прокурор/
- С.Нармандах /Удирдлагын академийн багш, судлаач/
- Д.Цолмон /Удирдлагын Академийн багш/

#### Долоо. Хугацаа:

- 2011 оны 06 дүгээр сарын 01-нээс эхлэн 2011 оны 09 дугаар сарын 01 хүртэл 3 сар

#### Найм. Судалгааны төслийн төсөв

| №   | Үйл ажиллагааны жагсаалт                                      | Тоо хэмжээ      | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ  |
|---|---|-----------------|----------------|-----------|
| <b>1.Иргэдийн оролцооны эрх зүйн зохицуулалтын талаар бэлэн байгаа судалгааны болон бодлогын баримт бичгүүдэд шинжилгээ хийх, тайлан боловсруулах</b> |   |                 |                |           |
| 1   | Судалгааны хэрэглэгдэхүүн, материал цуглуулах, хувилах зардал |                 |                | 100,000   |
| 2   | Судалгааны дүнг багийн гишүүдэд танилцуулах уулзалтын зардал  | 9хүн            | 15,000         | 135,000   |
| 3   | Судлаачын урамшуулал  | 2хүн<br>14хоног | 50,000         | 1,400,000 |



| <b>2. Одоогийн нэр бүхий хууль болон УИХ-аар хэлэлцэгдэх гэж буй хуулийн төслүүдэд иргэдийн оролцооны талаас нь үнэлгээ хийх, санал зөвлөмж боловсруулан гаргах</b> |  |                |         |                   |
|---|--|----------------|---------|-------------------|
| 1   | Үнэлгээний дүнг багийн гишүүд болон экспертүүдэд танилцуулах, санал авах уулзалтыг зохион байгуулах зардал |                |         | 80,000            |
| 2   | Үнэлгээний дүнг багийн гишүүд болон экспертүүдэд танилцуулах, санал авах уулзалтын зардал                  | 10хүн          | 15,000  | 150,000           |
| 3   | Багийн гишүүдийн урамшуулал  | 5хүн х 20хоног | 50,000  | 5,000,000         |
| 4   | Экспертийн урамшуулал  | 4хүн           | 200,000 | 800,000           |
| <b>3. Орон нутагт судалгаа хийх / Дорнод, Баянхонгор аймаг/</b>   |  |                |         |                   |
| 1   | Унааны зардал  | 2570км         | 500     | 1,285,000         |
| 2   | Томилолтын зардал  | 2хүн х 3хоног  | 20,000  | 120,000           |
| <b>4. Захиргааны зардал</b>   |  |                |         |                   |
| 1   | Бичиг хэрэг  | 3сар           | 50,000  | 150,000           |
| 2   | Байрын түрээс  | 3сар           | 150,000 | 450,000           |
| 3   | Хувилах зардал   | 1600хуудас     | 50      | 80,000            |
| 4   | Санхүүгийн тайлан гаргах   | 1хүн х 10хоног | 25,000  | 250,000           |
|   | <b>Нийт дүн</b>  |                |         | <b>10,000,000</b> |

Төслийг боловсруулсан:  
Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд хөдөлгөөний тэргүүн Р.Бурмаа



- Ерөнхийлөгчийн орон тооны бус зөвлөх Р.Бурмаа /Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн"-өөс хэрэгжүүлж буй “Орон нутгийн хөгжилд иргэдийн оролцоо” төслийн хүрээнд 2011.04.08-2011.04.10 ны өдрүүдэд Дорноговь аймагт ажиллаж орон нутгийн хөгжилд нийгмийн бүлгүүдийн оролцоог дээшлүүлэх, “Иргэний танхим”-ыг орон нутагт ажиллуулах нь сургалтанд оролцогсдод арга зүйн туслалцаа үзүүлэн зөвлөмж өгөв.
- Монгол “Шүүх эрх мэдлийн шинэчлэл ба шударга ёс” үндэсний чуулганы бэлтгэлийг хангах, зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан. “Шүүх эрх мэдлийн шинэчлэл ба шударга ёс” зургийн үзэсгэлэнд зураач урчуудыг урьж оролцуулан 8 уран бүтээлчийн 75 бүтээл ирсэнээс шилдэг 39 бүтээлийг сонгон үзэсгэлэн гаргасан. Үзэсгэлэнд оролцсон зураач урчуудыг шагнаж урамшуулах арга хэмжээг зохион байгуулсан. /Зураачдын бүтээлийг хамт хавсаргав./ Үндэсний чуулганы зохион байгуулалтын бэлтгэл ажлыг танхимын нийт ажилтанууд хийж гүйцэтгэв.

**“Шүүх эрх мэдлийн шинэчлэл ба шударга ёс” үндэсний чуулганд зориулан гаргасан**

**зургийн үзэсгэлэнд оролцсон зураачдын бүтээл**

Төрийн ордон

2011.04.14-15

| Зураачдын нэрс | №  | Бүтээлийн нэрс                                   | Тоо ширхэг | Бүтээлийн он |
|----------------|----|--|------------|--------------|
| Ц.Доржготов    | 1  | Тайлбаргүй /хог хаягдалын тухай/                 | 1          |              |
|                | 2  | Тайлбаргүй /Мод хамгаалах сэдвээр/               | 1          |              |
|                | 3  | Ил тод ардчилал                                  | 1          | 1990         |
|                | 4  | Тайлбаргүй /Хонь& чоно/                          | 1          | 1991         |
|                | 5  | Ганц баяр наадмаар уухгүй юм бол ,,,”,           | 1          |              |
| Ц.Байды        | 6  | Хорвоод багш минь өвгөрч дээ                     | 1          |              |
|                | 7  | Шидэт хивс                                       | 1          |              |
|                | 8  | Би хаана явнаа?                                  | 1          |              |
|                | 9  | Нарны нулимс                                     | 1          |              |
|                | 10 | Алтан төр минь авраач                            | 1          |              |
|                | 11 | Боож аллаа!                                      | 1          |              |
|                | 12 | Ахиад идчихмээр юм байна уу?                     | 1          |              |
| С.Цогтбаяр     | 13 | Үхлийг хүртэл авилгадан гэж үнэхээр их андууржээ | 1          |              |



|              |    |  |             |         |
|--------------|----|--|-------------|---------|
|              |    | чи,,,                                    |             |         |
|              | 14 | Авилгын хавх                             | 1           |         |
|              | 15 | Төрийн албанд орчихлоо                   | 1           |         |
|              | 16 | Мешок                                    | 1           |         |
|              | 17 | Монгол стандарт тогтооё                  | 1           |         |
|              | 18 | Ууж тасарсийм биш ээ<br>ахаа,,,          | 1           |         |
|              | 19 | Шүүх цагдааг шүүдэг хэн бэ<br>чи? аан,,, | 1           |         |
|              | 20 | Үзвэл үнс болчихно                       | 1           |         |
| А.Батбаяр    | 21 | Нохой сүүлээ сүүл<br>хонгорцогоо         | 1           |         |
|              | 22 | Өмч хувьчлалаар авсан юм<br>даа          | 1           |         |
|              | 23 | Төсөв                                    | 1           |         |
|              | 24 | Тайлбарлалтгүй                           | 1           |         |
| А.Бат-Эрдэнэ | 25 | Шударга ёс                               | 1           | 2011 он |
|              | 26 | Үнэн худал                               | 1           | 2011 он |
|              | 27 | Шударга ёс гэж байхгүй ээ                | 1           |         |
|              | 28 | Монгол Улсын нэрийн<br>өмнөөс            | 1           |         |
| Л.Санжмятав  | 29 | Хот тэлсээр                              | 1           |         |
|              | 30 | Газрын төлөө                             | 1           |         |
| Л.Өлзийбат   | 31 | Харь нутгийн хачин морьд                 | 1           | 2005    |
|              | 32 | Алтан дээр суусан<br>гуйлгачингууд,,,    | 1           |         |
|              | 33 | Муур багш                                | 1           | 2005    |
|              | 34 | Зээлээ төлчихөөд аваарай                 | 1           |         |
|              | 35 | Шинэ цагийн Монгол шатар                 | 1           |         |
|              | 36 | Халамж                                   | 1           |         |
| Н.Оргил      | 37 | Утаатай төр                              | 1           |         |
|              | 38 | Авлигатай төр                            | 1           |         |
|              | 39 | Шударга төр                              | 1           |         |
| <b>Бүгд</b>  |    |  | <b>39 ш</b> |         |



➤ Ерөнхийлөгчийн ХЭИОБ-ын зөвлөх Ч.Сосормаагийн өгсөн үүргийн дагуу 2011.05.03-05 ны өдрүүдэд Завхан аймагт томилолтоор ажиллан аймгийн “Иргэний танхим”-ын нээлтэнд оролцож танхимын анхдугаар хуралдааныг зохион байгуулах талаар арга зүйн туслалцаа үзүүлэв. “Иргэний танхим”-ын нээлтийн үеэр тус танхим анхныхаа хуралдааныг “XXI жишиг хороолол” сэдэвт нээлттэй хэлэлцүүлгээр эхэллээ.

Улиастай хот

2011.05.04

### **Ардчиллыг дахин ардчилахуй,,,**

Эрхэм хүндэт хадагтай, ноёдоо

Эрхэм хүндэт иргэд, төрийн болон орон нутгийн удирдах байгууллагын төлөөлөгчид Та бүхний энэ өдрийн амгаланг эрэн мэндчилье.

Монгол Улсын эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө цогтой тэмцэгч, Монгол төрийн нэрт зүтгэлтэн ах, дүү хоёр Жалханз хутагт, Дилав хутагт, Дорнын их яруу найрагч Бэгзийн Явуухулан, төрийн соёрхолт зохиолч Л.Ванган Ардчилсан төрийн анхны хоёр Ерөнхийлөгч Пунсалмаагийн Очирбат, Нацагийн Багабанди, академич Ц.Содном, төрийн түшээ Оюунхорол зэрэг Монгол түмний оюунбилэгт охид хөвгүүдийг төрүүлсэн Завхан нутгийн ард түмэн Та бүхэн эдүгээ цагын дор Монголын ардчилсан ололтын түүхийн бас нэгэн шинэ хуудсыг бүтээлцэж байгаад Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлье.

Одоогоос 20 гаруйхан жилийн өмнө Монголын ард түмэн хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн ардчилсан нийгмийг байгуулахын төлөө сэтгэл шулуудан аргамаг Цагаан хүлгийнхээ жолоог залсан нь иргэний нийгмийг цогцлоохоор өртөөлөн буухиалж, өнөөдрийн “Иргэний танхим”-тай золгож байна.

Ардчиллын үүр цайсан өнгөрсөн он жилүүдэд Монголчууд бид юуг олж бүтээж, юуг алдав?

Ямар ч их газрын баялаг, мал сүрэг, хөрөнгө мөнгөөр хэмжигдэшгүй нийгмийн баялагийг бид бүтээснийг захаас нь дурьдвал:

- хүний эрх эрх чөлөө,
- олон намын тогтолцоо,
- чөлөөт сонгууль,
- нутгийн өөрөө удирдах ёс,
- хувийн өмч хөрөнгөтэй байх,
- үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө, зэрэг тоочоод барашгүй нийт нийгмээрээ үр шимийг нь хүртэж буй эрх чөлөөг нэрлэнэ.

Үүнийг улс түмнүүд “Ардчиллын үнэт зүйлс, эрдэнэс” гэж нэрлэдэг ажээ. Тэгвэл бид “Ардчилал” гэж эрдэнэсээ авдрандаа хийсэн ард түмэн байж таарлаа.

Гэтэл дотоод, гадаадын судлаачид Монгол улсыг ардчиллын зүгт бодитой алхам хийсэн орнуудын тоонд зүй ёсоор оруулдаг боловч энэ нь тайвшрах зүйл огт биш гэж дүгнэдэг байна.



Монголын ардчилал балчир байна, ардчиллын төлөө эргэлт буцалтгүй замнаж байгаа гэж үнэлсэн боловч,,,, энэ нь Монгол улсад цаашид ардчилал улам бэхжиж, итгэлтэйгээр урагшилна гэсэн баталгаа бас биш юм” хэмээн дүн тавьжээ.

Бидний ардчиллаа хадгалсан авдар маань цоож, цуургагүй байна уу?

Бид 4 жил тутамд чөлөөт сонгуулиар, төрийн эрх барих дээд байгууллага болох УИХ, мөн орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болох нийслэл, аймаг, дүүрэг, сумын ИТХ-д өөрийгээ төлөөлөх хэн нэгэн иргэнийг сонгон итгэл хүлээлгэн илгээдэг. Үүнийг төлөөллийн ардчилал гэж нэрлэдэг.

Гэтэл төлөөллийн ардчиллыг дангаар хэрэглэснээс үүдэн гарч буй сөрөг талууд нь улс орнуудыг мухардалд оруулж буй сүүлийн үеийн олон жишээг бид дэлхийн олон оронд өрнөж буй үйл явцаас бэлхэнээ харж байна. Иргэдээс сонгогдсон төлөөлөгчид нь хууль батлах, төсөв хэлэлцэх, иргэдийн эрх ашгийг хөндсөн амин чухал асуудлуудад иргэдийн төлөөлөл болохоо умартан өөрсдийн бүлэглэлийн явцуу эрх ашгийн төлөө үйлчлэх явдал түгээмэл үзэгдэл болж, улмаар ардчилал нь бодит утга алдан, төлөөллийн ардчилал нь зарим талаар дарангуйллаас ялгагдахаа байж, улс төрийн хямрал нүүрлэх болжээ.

Ийм жишиг манай засаглалд, төрийн удирдлагад нүүрлэж байна уу? Нүүрлэж байвал хэрхэх вэ? Авдрандаа хадгалсан ардчиллаа хэрхэн хамгаалах вэ? Энэ тухай иргэд та бүхэн бодож үзсэн үү.

Хариулт нь их энгийн байна.

Улс орны болоод орон нутгийнхаа хөгжлийн аливаа асуудлыг шийдвэрлэхдээ том жижиг гэлтгүй, иргэдийнхээ санал байр суурийг сонсож тэднээр шийдүүлж байх өөрөөр хэлбэл орон нутгийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэдийг оролцуулах “Иргэний танхим”-аар дамжуулан нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж эрх ашиг нь хөндөгдөж буй талуудыг сонсох, байр суурийг нь харгалзах шилдэг арга бол тэднийг бодлогын үйл явцад оролцуулах явдал юм. Энэ үйл явцыг “шууд ардчилал” гэж олон улсад нэрлэдэг байна.

Төлөөллийн болон шууд ардчилал нь ардчиллын хоёр өөр төрөл бус, харин нэг нь нөгөөгөө нөхөж өгдөг нэгдмэл институци юм. Энэ хоёр зарчмыг хамтад нь зөв хослуулан хэрэглэснээр нийгмийн зөвшилцлийн хамгийн үр ашигтай механизм бүрддэг байна. Төрийн тогтолцооны бүх шатанд төдийгүй, компани, байгууллага, сургууль, хамт олны дунд нийгмийн ухамсар төлөвшиж, өндөр ёс зүйн орчин бүрдэх болно.

Шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангах нь ядуурлыг бууруулах, төрийн үйлчилгээг сайжруулах, төр, иргэний хамтын ажиллагааны түншлэлийг бэхжүүлэх, хөгжлийн бусад санаачлагуудыг амжилттай хэрэгжүүлэхэд маш чухал хөшүүрэг болдог байна.

Иргэд нутаг усандаа эзэн нь байх, өөрсдийн болон орон нутгийнхаа өмнө тулгарсан асуудлаа шийдвэрлэхэд өөрсдийн дуу хоолойгоор оролцох, гарах шийдвэр нь ард түмнийхээ өргөн хэлэлцүүлэг дор, тэдний санаа бодлын бодит тусгал болж хэрэгждэг байх зарчим ардчилсан орны үндсэн шинж юм.

Монголчууд бидний өмнө ардчилсан тогтолцооны суурь байгууламжийг бэхжүүлэх, ардчиллыг дахин ардчилах, иргэн төвтэй засаглалыг тогтоох, шууд ардчиллын суурийг тавих, төлөвшүүлэх зэрэг нийгмийг хамарсан өргөн хүрээтэй реформыг хэрэгжүүлэх шаардлага, эрэлт хэрэгцээ үүсэж байна.



Монголын түүхэнд төрийн бодлогын шийдвэр гарах түвшинд нийт иргэд тэгш эрхтэйгээр санал байр сууриа илэрхийлэн бодлогын үйл явцад байнга, тогтвортой оролцдог шууд ардчиллын тогтолцоо хэрэгжиж байсангүй. Тиймээс уламжлалт сэтгэлгээ, ажлын арга барил, асуудалд хандах хандлага, тогтсон үзэл, хүлээлт, хууль эрх зүйн орчин баримталж ирсэн дүрэм журам, хэм хэмжээ, зэрэг хэвшмэл ойлголт, хүчин зүйлс нь төр иргэний түншлэлийг төлөвшүүлэхэд саад бэрхшээл болж магадгүй. Хамгийн нарийн, төвөгтэй асуудлын нэг нь төрийн албан хаагчдаас иргэдийн санал хүсэлтэд өндөр мэдрэмжтэй хандаж, төрийн үйл хэрэгт оролцох иргэдийн Үндсэн хуулийн эрхийг баталгаажуулах явдал юм.

Ардчилсан тогтолцооны хүрээнд төрийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэд цоо шинэ сэтгэлгээ шаардагддаг. Төр болоод төрийн албан хаагчид “дарга байхын” төлөө бус харин хамтран зүтгэгч, шинийг эрэлхийлэгч байж иргэдэд үйлчлэх нь төрийн үүрэг хэмээн Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж төрийн эрх барих байгууллагууд болон ард түмэндээ хандан удаа дараалан мэдэгдэж байгааг Та бүхэн мэдэж буй биз ээ...

Монгол улсад шууд ардчиллын тогтолцоог эхлүүлэх, төлөвшүүлэх чиглэлд Ерөнхийлөгчийн хэрэгжүүлж буй бодлого үйл ажиллагаанас товч дурдъя.

Төр нь иргэдээ сонсдог, иргэд нь төрийн бодлого тодорхойлоход оролцдог, хөгжлийн аливаа асуудлыг олон түмнийг хамарсан нийгмийн хэлэлцүүлэг, иргэний бүтээлч оролцоогоор шийдвэрлэхийн чухлыг Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж бодлого үйл ажиллагааныхаа удирдлага болгон 2009 оны 12-р сарын 15-нд Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэд “Иргэний танхим”-ыг санаачилан байгуулсан болно. Өнгөрсөн хугацаанд тус танхимд улс орныг хамарсан нийгмийн цар хүрээтэй хууль эрх зүйн зохицуулалт механизмыг боловсронгуй болгох, нийгмийн тулгамдсан асуудлаар 108 удаагийн нээлттэй хэлэлцүүлэг хуралдаанууд зохион байгуулагдаж 5000 гаруй иргэд оролцож санал бодол байр сууриа илэрхийлээд байна.

Мөн Ерөнхийлөгчийн санаачилгаар “Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай” хуулийн төслийг УИХ-д өргөн барьж хууль батлагдан бодлогыг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулагдан эрчимтэй ажиллаж байна. Төсвийн төвлөрлийг сааруулах, орон нутагт төсвийн эрх мэдлийг шилжүүлэх, шинэтгэлийг эхлүүлэхээр “Төсвийн тухай” хуулийн шинэчилсэн төсөл, “Дээд боловсролын санхүүжилт суралцагчдын цалин тэтгэлэг тэтгэмж, нийгмийн баталгааны тухай” хуулийн төслүүдийг тус тус өргөн барьж эдгээр төслүүд нь УИХ-ын энэ хаврын чуулганаар хэлэлцэгдэх шатандаа ороод байна.

Ерөнхийлөгчийн санаачилсан “Иргэний танхим”-ын жишгээр Дархан-Уул, Булган, Хөвсгөл, Дорноговь, Өмнөговь, Орхон аймгууд, УБ хот, Хан-Уул, Баянгол дүүргүүдэд “Иргэний танхим”-ууд байгуулагдаад байна.

Төрийн болон орон нутгийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явц дахь иргэний оролцооны өнөөгийн нөхцөл байдал, хууль эрхзүйн орчинд дүн шинжилгээ хийх, зохицуулалтын механизмуудыг боловсронгуй болгох сайжруулах зорилгоор Ерөнхийлөгчийн дэргэд ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Өнөөдөр Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэх, хөгжүүлэх асуудлыг хариуцсан улс төрийн бус институци байхгүй байна гэхэд болно. Шууд ардчилал, төвлөрлийг сааруулах нь төрийн зохистой бодлого, үйл ажиллагааны нэгдсэн уялдааг оновчтой хангах, судалгаа хийх, мэдээллийн сан бүрдүүлэх, боловсрол олгох, соён гэгээрүүлэх, гарын авлага, сургалтын материал бэлтгэх, зөвлөмж гаргаж байх зорилготой судалгааны институт байгуулахыг ч судлан үзэж байна.





Гадаадын нэр хүнд бүхий байгууллагууд тухайлбал, Швейцарийн хөгжлийн агентлагтай хамтран шууд ардчиллыг орон нутагт хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд туршилтын сумын төслийг хэрэгжүүлэх, төслийг түшиглэн шууд ардчиллын сүлжээний суурийг тавих зэрэг олон санал санаачлагуудыг судлан үзэж байна. Энэ нь өөрөө эргээд ардчиллын дархлааг бэхжүүлэх нэг гол бүтэц болох юм. Ийнхүү бодлогын болон зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд ихээхэн анхаарал хандуулан ажиллаж байна.

Төвлөрлийг сааруулах, орон нутаг, иргэдэд эрх мэдэл олгох, иргэдийн оролцоог хангах чиглэлээр иргэдийг оролцооны соёлд сургах, орон нутгийн төрийн албан хаагчдыг сургаж бэлтгэх, гарын авлага материалаар хангах асуудал ч тэргүүн зэргийн ач холбогдолтой болж байна.

Монгол Улс иргэдийнхээ ардчиллын талаархи улс төрийн боловсролд төсөв хөрөнгө зарцуулдаггүй, энэ асуудлыг урсгалд нь хаясан цорын ганц ардчилсан орон гэхэд болно. Энэ чиглэлд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд бүхэлдээ гадны байгууллагуудын санхүүжилт, иргэдийн идэвхи санаачлага дээр тулгуурлан явагдаж иржээ.

Энэ чиглэлээр үндэсний хэмжээний хөтөлбөр боловсруулж батлан, хэрэгжүүлэх шаардлага ч үүсэж байна. Бид хийж чадвал бариа ойрхон байна.

Монгол Улсын ирээдүйн хөгжлийн тулгын чулуу болох ардчилсан үнэт зүйлсийг иргэний оролцоогоор хамгаалан баталгаажуулахад орон нутагт байгуулагдаж буй Иргэний танхимууд асар их үүргийг гүйцэтгэх нь дамжиггүй юм.

Завхан аймгийн “Иргэний танхим” өнөөдөр анхдугаар нээлттэй хэлэлцүүлгээрээ “21 зуун жишиг хороолол” хэлэлцүүлгийг зохион байгуулж орон нутаг дахь шууд ардчиллын суурийг тавьж байна.

Хүний амьдралд тэр бүр тохиодоггүй нийгмийн шинэчлэлийн хүрдийг эргүүлэх түүхэн энэ өдөр Завхан аймгийн “Иргэний танхим”-ын нээлтэд хүрэлцэн ирсэн Та бүхэн хамгийн азтай иргэд байлаа.

Завхан нутгийнхаа ард иргэдийн эрхийг хүндэтгэн энэхүү “Иргэний танхим”-ыг байгуулах санаачилга гаргасан аймгийн ИТХ, Засаг дарга Я.Санжмятав болон ЗДТГазрын нийт хамт олон үүнийг санаачлахад бүтээн байгуулахад оролцсон, хамтран ажилласан иргэд, аж ахуйн нэгж, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчид та бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Богд Очирваань хайрхан шигээ Завхан нутгийн хөгжил цэцэглэл, хүн зоны амьдрал өөдлөн дэгжихийн өлзийт ерөөлийг өргөн дэвшүүлье.

Анхаарал тавьсан Та бүхэнд баярлалаа.

Завхан аймгийн “Иргэний танхим”-ын нээлтэнд  
Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх  
“Иргэний танхим”-ын асуудал эрхэлсэн зөвлөх  
Д.Аззаяагийн хэлсэн үг





➤ Эдийн засгийн бодлогын зөвлөх Л.Дашдоржийн өгсөн үүргийн дагуу 2011.05.27-нд “Орон нутгийн эрх мэдлийг иргэдийн оролцоотой нэмэгдүүлэх нь” чуулганы бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдон ажилласан.

Салбар хуралдаан 1: “Төсвийн ил тод байдал, иргэдийн оролцоо”

Салбар хуралдаан 2: “Орон нутгийн эрх мэдлийг иргэдийн оролцоотой нэмэгдүүлэх нь” /А танхимд/

Салбар хуралдаан 3: “Иргэдийн оролцооны хууль, эрх зүйн орчин”  
/В танхимд/ хуралдаж нийт 220 төлөөлөгч чуулганд оролцсон.

“Орон нутгийн эрх мэдлийг иргэдийн оролцоотой нэмэгдүүлэх нь” чуулганы 12 цагийн протоколыг шивж буулгаж Эдийн засгийн бодлогын зөвлөх Л.Дашдоржид хүлээлгэн өгөв.

➤ Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга Ч.Сайнбилэгийн үүрэг болгосоны дагуу Ерөнхийлөгчийн Тамгын газраас “Ёс зүйн харицлагын жилд хийх ажлын төлөвлөгөө”-нд санал өгөв.

## **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРААС ЁС ЗҮЙН ХАРИУЦЛАГЫН ЖИЛД ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ОРУУЛАХ САНАЛ**

2011.04.21

*Эх орон, ард түмнийхээ төлөө эрдэм чадлаа зориулж, төрийн хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэхээ тангаргалая.  
Тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ.*

*/Төрийн албаны тухай хуулийн 12.1/*

1. Монгол Улсад мөрдөгдөж байгаа ёс зүйн асуудалтай холбогдох төрийн албан тушаалтануудын ёс зүйн хэм хэмжээ тогтоосон дүрэм журмууд, өргөдөг тангараг, ёс зүйн хэрэгжилтэнд хяналт тавих байгууллагын танилцуулга, олон улсын гэрээ, конвенц, дүрэм журмууд, ёс зүйн зөрчлийн талаар өөрийн гомдолоо хэнд, хэрхэн гаргах, захидал хэрхэн бичих, шүүх, захиргааны хэргийн шүүхэд хэрхэн хандах талаар ирэгдэд мэдээллийг өргөн хүрээгээр хүргэх,

2. Төр засгийн байгууллагуудын зүгээс үзүүлж буй үйлчилгээний чанар муу байгаад олон түмэн улам бүр гомдол санал гаргах болсон нь төрийн алба үйл ажиллагаандаа зарчим болгодог ёс зүйн хэм хэмжээ алдагдсан болон хэрэгжихгүй байгаатай холбоотой. Гэвч манай улсад ёс зүйн талаарх хууль дүрмийг тайлбарласан тайлбар, дүрэм, журмууд нь иргэдэд нээлттэй биш, олж авахад төвөгтэй, тэр байтугай нийтийн номын сан, мэдээллийн төвүүдэд, онлайн сайтуудад төдийлөн харагдахгүй байдаг. Өнөөдөр тодорхой хүрээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа ёс зүйн хэм хэмжээг удирдах зөвлөл нь баталдаг боловч тэр нь хаана, хэнд хадгалагдаж байдаг болон олон нийтэд нээлттэй биш учир иргэдийн албан тушаалтануудын ёс зүйгүй үйлдэлээс иргэд өөрсдийгээ хамгаалах эрх нь зөрчигдөж байна. Төрийн албан тушаалтануудын ёс зүйг сахиулах болон тэдний ёс зүйгүй үйлдэл /эс үйлдэхүй/-гээс иргэд өөрийгээ хэрхэн хамгаалах гомдол маргааныг хэрхэн барагдуулах талаар хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран сурталчилгаа явуулах,

3. Ёс зүйн асуудлаар их дээд сургууль, албан байгууллагууд, иргэдийг оролцуулсан мэтгэлцээн, телевизийн нэвтрүүлэг явуулах, ёс зүйн сургалт семинар зохион байгуулах,



## Байгууллагын хүрээнд

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын ажилтан, албан хаагчдын ёс зүйн дүрмийг */Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2010 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 51 дүгээр захирамжаар батлагдсан/* сахин хэрэгжүүлж, хэрэглэж хэвших,
2. ЕТГ-ын Удирдах албан тушаалтан, зөвлөхүүд, ажилтан албан хаагчдын ёс зүйн байдлын талаар нийт ажилтан албан хаагчдын дунд жилд 1-2 удаа */anonymity/* нэргүй санал асуулга явуулж байх,
3. Ёс зүйн зөрчил гаргасан аливаа албан хаагчдад, ажилтануудад зохих арга хэмжээ авч сахилгын шийтгэл хүлээлгэдэг байх, Үүнд:
  - сануулах,
  - Үндсэн цалинг 2-3 сарын хугацаагаар 2-30%-иар бууруулах,
  - тухайн албан тушаалд ажиллах эрхийг түдгэлзүүлэх,
  - хөдөлмөрийн гэрээг цуцлах, гэх мэт шат дараалсан арга хэмжээ авч байх /
4. Ёс зүйн дүрмийг бүрнээ биелүүлж баримтлан ажиллахаа илэрхийлж нийт ажилтан, албан хаагчид гарын үсэн зурж захиргаандаа хадгалуулж хэвших,
5. Төрийн өндөр албан тушаал хашиж байгаа албан хаагчид, ажилтанууд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Монголын ард түмний өмнө хүлээсэн үүрэг хариуцлага, бодлого үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах зүйлсийг анхаарах,
  - гарсан шийдвэрийн биелэлтийг хангахад аливаа байдлаар саад учруулж цаг алдуулахгүй шуурхай ажиллах,
  - хамт ажиллаж байгаа хүмүүсийн эрхийг хүндэтгэх, төр засгаас хүлээлгэсэн итгэлийг дааж ажиллах,
  - бодлогын чанартай шийдвэр, хууль болон түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан заавар, журмыг чанд мөрдөж ажиллах, хүнд суртал гаргах, чирэгдүүлэхгүй байх, хувийн үзэмжээр аливаа асуудалд хандаж зөрүүдлэн муйхарлахгүй байх,
  - ажилтан албан хаагчдын нэр төрийг хүндэтгэн зан харьцааны дутагдал гаргахгүй байх, хамт олныг хүндэтгэн ажиллах,
  - үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах нөхцөлөөр ханган ажиллах,

Санал бичсэн:

Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын иргэний танхимын  
асуудал хариуцсан зөвлөх  
Д.Аззаяа

➤ Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга Ч.Сайнбилэгийн үүрэг болгосоны дагуу 2011-2012 онд Ерөнхийлөгчийн Тамгын газраас “Иргэний танхимын үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгө оруулалтын төсвийн захиалгын саналыг бэлтгэж өгөв.



**Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх “Иргэний танхим”-ын үйл  
ажиллагаанд шаардагдах тоног төхөөрөмжийн захиалга**

2011.05.17

| 2011-2012 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл                       | Эхлэх, дуусах хугацаа | Тоо ширхэг | Төсөвт өртөг                   |
|---|-----------------------|------------|--------------------------------|
| Орчуулгын тоног төхөөрөмж   | 2012 оны 01-р улирал  | 50 ш       | 25 000 000 ₮                   |
| Нээлттэй хэлэлцүүлэгт орон нутгын иргэдийг оролцуулах телемост техник тоног төхөөрөмж | 2012 оны 01-р улирал  |            | 27 000 000 ₮                   |
| Жижиг оврын хэвлэх үйлдвэр  | 2012 оны 01-р улирал  | 1          | 30 500 000 ₮<br>Буюу 25 000 \$ |
| Телестудийн техник тоног төхөөрөмж  | 2012 оны 01-р улирал  | 1          | 18 300 000 ₮<br>15 000 \$      |
| Нийт  |                       |            | 100 800 000 ₮                  |

| 2011 оны төсвийн хөрөнгө оруулалтаар авах эд хогшил |                      |      |   |
|---|----------------------|------|---|
| Иргэний танхимд сандал                              | 2011                 | 30 ш | Иргэний танхим”-ын ажлын албаны өрөөнд байрлуулах эдгээр тавилга хогшлыг энэ оны тавилга хөрөнгө эд хогшил худалдан авах төсвөөс гүйцэтгэлийг хийхийг санал болгож байна. |
| Иргэний танхимын ажлын албаны өрөөнд ажлын ширээ    | 2011                 | 4 ш  |   |
| Иргэний танхимын ажлын албаны өрөөнд ажлын сандал   | 2011                 | 4 ш  |   |
| Ном, бичгийн шүүгээ                                 | 2012 оны 01-р улирал | 1 ш  |   |
| Хурлын ширээ  | 2011                 | 1 ш  |   |
| Хурлын ширээний сандалнууд                          | 2011                 | 8 ш  |   |

Захиалгат санал өгсөн:  
“Иргэний танхим”-ын асуудал  
эрхэлсэн зөвлөх Д.Азаяа



- 2011.04.15-16 ны өдрүүдэд хуралдсан “Шүүх эрх мэдлийн шинэчлэл ба шударга ёс” үндэсний чуулганаас гаргасан дүгнэлт шийдвэрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны хүрээнд 2011.06.22-ны өдөр ажлын хэсгээс зохион байгуулсан “Шүүхийн шинэтгэлийн багц хуулиудын төслийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, хуралдааны гурван цагын аудио бичлэг нийт хуудас протоколыг шивж буулган 2011.06.24 ны өдөр Ерөнхийлөгчийн ахлах зөвлөх П.Цагаанд хүлээлгэн өгөв.

Тайлан гаргасан: Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх “Иргэний танхим”  
Д.Аззаяа